

**1. Улсын тэтгэвэр, олон нийтийн тэтгэврийн тогтолцооны ерөнхий агуулга**

- 1) Япон улсад оршин сууж буй 20-оос дээш 60 хүртэлх насны Японы иргэд болон гадаадын харьяат иргэд нь хуулинд заасны дагуу улсын тэтгэвэрт хамрагдаж, тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөх үүрэгтэй байдаг.
- 2) Улсын тэтгэврийн тогтолцоо нь нийгмийн харилцаанд оролцогчид нь харилцан туслалцах, асран халамжлах гэсэн зарчимд тулгуурлан оршин тогтнодог болно.
- 3) Улсын тэтгэврийн тогтолцоонд өндөр насны тэтгэврээс гадна шаардлагатай үед олгогддог тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр ч багтдаг.
- 4) Улсын тэтгэврээс олгогдох тэтгэврийн нэг хэсгийг төр хариуцдаг.
- 5) Улсын тэтгэврийн даатгалд төлсөн шимтгэлийн нийт дүнг нийгмийн даатгалын шимтгэл төлсөнд тооцон, татвараас чөлөөлдөг.

**2. Улсын тэтгэвэрт хамрагсад болон хамрагдах журам**

Улсын тэтгэвэрт хамрагсад нь доорхи 3 ангилалд хуваагддаг бөгөөд дор дурдсаны дагуу хамрагддаг.

- 1) 1-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагсад:  
Япон улсад оршин сууж буй 20-оос дээш 60 хүртэлх насныхан ба дор дурдсан 2-р, 3-р ангилалд хамрагдахгүй хүмүүс.  
→ 1-р ангилалд хамрагдах гадаадын харьяат иргэд нь хот, дүүрэг, суурин, тосгоны захиргаанд очиж оршин суугчдын бүртгэлд орсоны дараа тухайн захиргааны улсын тэтгэврийн бүртгэлийн хэсэгт очиж бүртгэлд хамрагдана.  
→ Тэтгэврийн даатгалын шимтгэлийг Япон улсын тэтгэврийн байгууллагаас илгээсэн төлбөрийн бичгийн дагуу төлнө.  
(Дэлгэрэнгүйгээр: «4. Сар бүрийн тэтгэврийн даатгалын шимтгэл»)  
Жич: Японы иргэншилгүй, эмчилгээний виз эсвэл урт хугацааны жуулчны визээр оршин суудаг хүмүүс үндэсний тэтгэврээс чөлөөлөгдөнө.
- 2) 2-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагсад:  
Үйлдвэр, аж ахуйн газрын ажилтан, албан хаагчид буюу ажиллагсдын тэтгэврийн даатгалд хамрагдах хүмүүс.  
→ Тэтгэвэрт хамруулж бүртгүүлэх ажлыг тухайн ажил олгогч нь хариуцах бөгөөд даатгуулагч өөрөө бүртгүүлэх шаардлагагүй. Дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн ажлын газраасаа авна уу!  
→ Тэтгэврийн даатгалын шимтгэлийг ажил олгогч нь цалингаас бодож суутгана.
- 3) 3-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагсад:  
II ангиллын даатгуулагчийн хамааралтай 20-59 насны Японд амьдардаг бол, III ангиллын даатгуулагч болно.  
→ Тэтгэвэрт хамруулах ажлыг 2-р ангиллын тэтгэврийн даатгуулагч нь өөрийн ажил олгогчоор дамжуулж хийж гүйцэтгэнэ.  
Дэлгэрэнгүй мэдээллийг тэжээгч болох нөхөр /эхнэрийн/ ажлын газраас авна уу!  
→ Тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхгүй. 2-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагдаж буй даатгуулагч шимтгэлийн төлбөрийг хариуцана.  
→ Хэрэв та Япон улсаас гадагш түр хугацаагаар явах бол, III зэрэглэлийн даатгуулагч болж болно.

**3. Тэтгэврийн дэвтэр**

Улсын тэтгэвэрт хамрагдах бүртгэл дууссаны дараа тэтгэврийн дэвтэр олгогдоно. Тэтгэврийн дэвтэр нь тэтгэвэр авах болон тэтгэврийн талаар зөвлөгөө авахад биеийн байцаалт болдог чухал баримт бичиг юм. Насан турш ашиглах учраас ариг гамтай эдэлж, сайтар хадгалах шаардлагатай.

Хэрэв дэвтрээ бохирдуулсан, хаяж үрэгдүүлсэн тохиолдолд 1-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагсад нь орон нутгийн тэтгэврийн байгууллага ба оршин суугаа орон нутгийн засаг захиргааны байгууллагад хандаж, 2-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагсад нь орон нутгийн тэтгэврийн байгууллага ба ажил олгогчоор дамжуулан, 3-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагсад нь ажил олгогчоор дамжуулан дахин олгуулах хүсэлтийг гаргана.

**4. Сар бүрийн тэтгэврийн даатгалын шимтгэл**

Үндэсний тэтгэврийн шимтгэлийн хувь хэмжээ нь 2021 оны 4-р сараас 2022 оны 3-р сар хүртэл нэг сард 16,610 иэн байна. Сар бүрийн шимтгэлийг дараа сарын эцэс хүртэл төлнө.

Шимтгэлийн төлбөрийг банк санхүүгийн байгууллага, шуудан, 24 цагийн дэлгүүрт бэлнээр, интернэт банкны автомат шилжүүлэг болон зээлийн картаар төлбөрөө хийх боломжтой.

Мөн түүнчлэн тодорхой хугацааны шимтгэлийг урьдчилж төлбөл шимтгэлийн хэмжээг буруулдаг тогтолцоо ч бий. Ялангуяа бэлнээр урьдчилж төлснөөс дансаар урьдчилж төлбөл шимтгэлийн хэмжээг бууруулах хувь нь их болдог.

**5. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөхөд хүндрэлтэй үед (Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх тогтолцоо)**

Орлого багатай гэх зэрэг шалтгаанаар тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлөхөд хүндрэлтэй үед хот, дүүрэг, суурин, тосгоны захиргаанд хандаж тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх хүсэлтийг гаргаж болно.

Тэтгэврийн байгууллага нь өмнөх жилийн орлого зэргийг хянаж шалгаад зөвшөөрсөн тохиолдолд тэтгэврийн даатгалын шимтгэлийн төлбөрөөс чөлөөлөх буюу нэг хэсгийг хөнгөлдөг.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг хөнгөлөх тогтолцооны төрөл, төлөх шимтгэлийн хэмжээ, шимтгэлийг бүтэн төлсөн үетэй шимтгэлийг хөнгөлсөн үеийг харьцуулсан өндөр насны суурь тэтгэврийн хэмжээ нь баруун талын хүснэгтийн дагуу болно.

«Анхаарах зүйл»

- 1) 1/4, 1/2 болон 3/4 хувийн хөнгөлөлтийн төлбөрийг хийгээгүй тохиолдолд тухайн хөнгөлөлт нь хүчингүй болж, шимтгэл төлөөгүйтэй адилтган үзэх учраас ирээдүйд авах өндөр насны суурь тэтгэврийн хэмжээнд тооцогдохгүйгээр зогсохгүй шаардлагатай үед олгогддог тахир дутуугийн тэтгэвэр, тэжээгчээ алдсаны тэтгэвэр зэргийг авч чадахгүй байдалд хүргэж болзошгүй тул анхаарна уу!
- 2) Оюутанд зориулсан төлбөрийн тусгай тогтолцоог зөвхөн оюутан ашиглаж болно. Гэхдээ тус тогтолцоо нь зарим нэг сургуулиас бусад гадаадын боловсролын байгууллагын Япон дахь салбар сургуулиудад хамаарахгүй. Мөн богино хугацааны сургалтанд хамаарахгүй.

Хөнгөлөх тогтолцооны төрөл	Шимтгэлийн хэмжээ	Өндөр насны суурь тэтгэврийн хэмжээ
Бүрэн чөлөөлөх	0 иен	8-ны 4
1/4 төлөх (3/4 хөнгөлөх)	4,150иен	8-ны 5
1/2 төлөх (1/2 хөнгөлөх)	8,310иен	8-ны 6
3/4 төлөх (1/4 хөнгөлөх)	12,460 иен	8-ны 7
Төлөх хугацааг хойшлуулах тогтолцоо	0 иен	0
Оюутанд зориулсан төлбөрийн тусгай тогтолцоо	0 иен	0

**6. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлөх**

Бүрэн чөлөөлөгдсөн ба хөнгөлөгдсөн хугацааны төлбөрийг 10 жилийн дотор нөхөн төлж болно. Нөхөн төлсөн тохиолдолд ирээдүйд авах өндөр насны суурь тэтгэврийн хэмжээг тооцоход даатгалын шимтгэлийг бүтэн төлсөнтэй адилтгаж үзнэ.

Гэхдээ чөлөөлөх болон хөнгөлөх шийдвэр гарсан жилийн дараахь жилээс эхлэн тоолж 3 дахь жилээс хойш нөхөн төлсөн тохиолдолд тухайн үеийн даатгалын шимтгэлд тодорхой хэмжээний төлбөрийг нэмж тооцно.

**7. Улсын тэтгэврээс олгогдох тэтгэврийн хэмжээ**

1) Өндөр насны суурь тэтгэвэр

Улсын тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10 жилээс дээш төлсөнг.м. бусад болзлыг хангасан хүмүүст 65 наснаас эхлэн тэтгэврийг олгоно.

\* Тэтгэврийн хэмжээ = ¥780,900 иен (40 жилийн турш шимтгэл төлсөн тохиолдолд 2021 онд авах жилийн тэтгэвэр)

2) Тахир дутуугийн суурь тэтгэвэр

Улсын тэтгэвэрт хамрагдаж буй хугацаанд бэртэж гэмтсэн ба өвчтэй болсны улмаас тахир дутуугийн 1-р болон 2-р группд орсон тохиолдолд олгогдоно.

\* Тэтгэврийн хэмжээ = 976,125 иен (1-р групп, 2021 онд авах жилийн тэтгэвэр)  
780,900 иен (2-р групп, 2021 онд авах жилийн тэтгэвэр)

3) Тэжээгчээ алдсаны суурь тэтгэвэр

Улсын тэтгэвэрт хамрагдаж буй хугацаанд нас барсан даатгуулагчийн асрамжид байсан ар гэрийнхэнд (хүүхэдтэй нөхөр /эхнэр/, хүүхэд) олгогдоно.

\* Тэтгэврийн хэмжээ = 1,005,600 иен (1 хүүхэдтэй нөхөр /эхнэр/-т 2021 онд олгох жилийн тэтгэвэр)

\* 65 нас хүрэхээсээ өмнө Японы иргэншил авсан болон байнгын оршин суух зөвшөөрөлтэй гадаадын харьяатын гадаадад амьдарч байсан хугацааны 1961 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн Японы иргэншил авсан өдрийн өмнөх өдөр хүртэлх 20-оос дээш 60 хүртэлх насны хугацааг 10 жилийн тэтгэвэр авах эрхийн хугацаанд нэмж тооцно (нэмж тооцох хугацаа гэж нэрлэдэг). Энэхүү нэмж тооцох хугацаа нь өндөр насны суурь тэтгэврийг авах эрхтэй эсэхийг харгалзан үзэхэд нэмж тооцож болдог боловч өндөр насны суурь тэтгэврийн хэмжээг бодож тооцоолоход харгалзахгүй.

\* Тахир дутуугийн суурь тэтгэвэр ба тэжээгчээ алдсаны суурь тэтгэврийг авахад тодорхой хэмжээний даатгалын шимтгэлийг төлсөн байх шаардлагатай бөгөөд тус шаардлагыг хангаагүй тохиолдолд авч чадахгүй. Дэлгэрэнгүй мэдээллийг (10. Улсын тэтгэвэртэй холбоотой зөвлөгөө болон лавлагаа авах газар) - д бичигдсэн хаягаар лавлана уу!

**8.Тэтгэврээс гарахад нэг удаа олгох мөнгө**

Улсын тэтгэврийн даатгалын шимтгэлийг төлсөн хугацааны (2-р, 3-р ангиллын тэтгэврийн даатгалд хамрагдсан хугацааг оролцуулахгүй) нийлбэр нь 6 сараас дээш бөгөөд өндөр насны суурь тэтгэвэр авах хугацааны болзлыг хангаагүй гадаадын харьяат иргэд нь Японд оршин суух хаяггүй болсон өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд тэтгэврээс гарахад нэг удаа олгох мөнгийг нэхэмжилж болно.

Таны тэтгэврийн дүн шимтгэл төлсөн сарын дүнгээс хамаарна. Энэ хүснэгтэд таны тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн сүүлийн сар 2021 оны 4 сараас 2022 оны 3 сар байсан тохиолдолд олгогдох тэтгэврийн дүнг жишээгээр харуулсан байна. Таны төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн сүүлийн сар 2021 оны 3 сараас өмнө байх тохиолдолд олгогдох тэтгэврийн дүнгийн талаар манай вэбсайтаас харна уу.

\*Даатгалын шимтгэлийг төлсөн хугацааны нийлбэрийг дараах аргаар бодож тооцно.  
Шимтгэлийг бүтэн төлсөн сарын тоо + (1/4 төлсөн сарын тоо) x 1/4 + (1/2 төлсөн сарын тоо) + (3/4 төлсөн сарын тоо) x 3/4

Даатгалын шимтгэлийг төлсөн хугацааны нийлбэр *	Олгогдох мөнгө
6 сараас 11 сарын хугацаанд	49,830 иен
12 сараас 17 сарын хугацаанд	99,660 иен
18 сараас 23 сарын хугацаанд	149,490 иен
24 сараас 29 сарын хугацаанд	199,320 иен
30 сараас 35 сарын хугацаанд	249,150 иен
36 сараас 41 сарын хугацаанд	298,980 иен
42 сараас 47 сарын хугацаанд	348,810 иен
48 сараас 53 сарын хугацаанд	398,640 иен
54 сараас 59 сарын хугацаанд	448,470 иен
60 сараас дээш хугацаанд	498,300 иен

«Нэхэмжлэх журам»

(1) Шилжилт хөдөлгөөн болон Үндэсний тэтгэвэрт хамрагдах эрхгүй болсон тухай мэдүүлгээ оршин суух харьяалалтай хот, хотхон, тосгоны тамгын газар өгнө үү.

(2) Япон улсаас гарсныхаа дараа тэтгэврийн даатгалаас гарсны тэтгэмж хүсэх тухай маягтын шаардлагатай хэсгийг уг маягтын анхааруулах хэсэгт бичигдсэн байгаа мэдээллийг лавлаж бөглөнө үү. Бөглөсөн маягтаа агаарын шуудангаар дараах хаягаар илгээнэ үү. Япон улсын Тэтгэврийн даатгалын байгууллага, Токио хот, Сүгинами дүүрэг, Такайдониши 3-5-24, 168-8505 Япон улс

Тэтгэврийн даатгалаас гарсны тэтгэмж хүсэх тухай маягтыг аль ч хотын захиргааны Үндэсний тэтгэврийн даатгалын хэлтэс, Япон улсын Тэтгэврийн даатгалын байгууллага (JPS)-ын салбар, вэбсайтаас татаж авах боломжтой.

(<https://www.nenkin.go.jp/international/index.html>)

【Анхааруулга】 Хэрэв та нэг удаа тэтгэврийн даатгалаас гарсны тэтгэмж авсан тохиолдолд таны урд өмнө хамрагдаж байсан тэтгэврийн даатгалын баталгаат хугацаа хүчингүй болно. Улмаар тэтгэврийн даатгалаас түр гарсны тэтгэмж авах хүсэлт гаргахын өмнө ирээдүйд тэтгэвэр авах боломжийн эсэх тухай сайтар тунгаана уу.

**9. Нийгмийн даатгалын гэрээ хэлэлцээрийн тухай**

Япон болон бусад улс оронтой байгуулах хоёр улс хоорондын нийгмийн хамгааллын хэлэлцээрт үндэслэн Япон улс руу богино хугацаагаар илгээсэн хөдөлмөр эрхлэгч Япон улсын даатгалын тогтолцооны дагуу заавал хамрагдах эрх үүргээс чөлөгдөх, эсвэл хоёр улсын тэтгэврийн даатгалд хамрагдаж байсан хугацааг нэгтгэх боломжтой. Дэлгэрэнгүй мэдээллийг манай вэбсайтаас харна уу. (<https://www.nenkin.go.jp/international/index.html>)

**10. Улсын тэтгэвэртэй холбоотой зөвлөгөө болон лавлагаа авах газар**

Улсын тэтгэврийн талаар лавлагаа авахдаа тэтгэврийн дэвтрээ зэхээд, оршин суугаа хот, дүүрэг, суурин, тосгоны захиргаа болон орон нутгийн тэтгэврийн байгууллагад хандана уу! Орон нутгийн тэтгэврийн байгууллагын офисын байршил, хаягийг дараахь жагсаалтаас тодруулна уу! (<https://www.nenkin.go.jp/international/index.html>)

Мөн түүнчлэн утсаар лавлагаа авах тохиолдолд дараахь «NENKIN Dial»-ийн тусгай дугаараар залгана уу! (Зарим гадаад хэлний орчуулгын тухайд үнэгүй үйлчилгээ авах боломжтой.)

Лавлагаа хийхэд тэтгэврийн дугаар бичигдсэн тэтгэврийн дэвтэр шаардлагатай болох тул зэхэж бэлдэнэ үү!

- «NENKIN Dial» -ийн орон нутгийн дуудлага 0570-05-1165 (хот хоорондын дуудлагын хөлсийг төлнө)
- «NENKIN Dial» -ийн гадаад дуудлага +81-3-6700-1165 (гадаад дуудлагын хөлсийг төлнө)

